

МОНГОЛ УЛС  
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ  
ТОГТООЛ

1995 оны 11 дугаар  
Сарын 28 –ны өдөр

Дугаар 47

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хувьцаат компанийн гишүүдийн хурал хуралдуулах, ногдол ашиг хуваарилахад “Бүртгэх өдөр” тогтоож, хуралд оролцох хувьцаа эзэмшигч эрх бүхий гишүүдийг тодруулж байх тухай Монголын Хөрөнгийн биржээс ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Үнэт цаасны хорооноос ТОГТООХ нь:

1. “Хувьцаат компанийн гишүүний бүрэн эрхийг баталгаажуулах тухай” журмыг хавсралтад дурдсанаар баталсугай.

2. Энэ журмыг мөрдөж ажиллахыг хувьцаат компанийн удирдлагуудад даалгасугай.

3. Эрх бүхий гишүүдийн бүртгэлийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж, хувьцаат компанид өгч байхыг Монголын Хөрөнгийн бирж /н.ЗОЛЖАРГАЛ/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН

Монгол Улсын Үнэт цаасны хорооны 1995  
оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 47 дугаар  
тогтоолын хавсралт

ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГИШҮҮНИЙ  
БҮРЭН ЭРХИЙГ БАТАЛГААЖУУЛАХ  
ТУХАЙ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Хувьцаат компанийн хурлыг хуралдуулах эрх бүхий этгээд гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах болох ногдол ашиг хуваарилахад гишүүдийн бүрэн эрхийг баталгаажуулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

ХОЁР. Бүртгэх өдөр тогтоох нь

2. Хувьцаат компанийн гишүүдийн ээлжит болон ээлжит бус хурлын товыг хурал хуралдуулахаас 30 хоногийн өмнө төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

3. Гишүүдийн хурлаар тухайн компанийн баланс тайлан хэлэлцэж батлах үед хувьцаа эзэмшигчид ногдол ашиг хуваарилах, эсэх тухай хэлэлцэж шийдвэр гаргана.

4. Хуваарилахаар тогтоосон ногдол ашгийг шийдвэр гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор багтаан олгоно.

5. “Бүртгэх өдөр” гэж тогтоосон өдрөөр тасалбар болгон Хөрөнгийн биржээс хуралд оролцох болон ногдол ашиг авах эрх бүхий хувьцаа эзэмшигчдийг компанид тодорхойлж өгөх өдрийг хэлнэ.

6. Хуралд оролцох эрх бүхий гишүүдийг тодруулахын тулд “бүртгэх өдрийг” хурал хуралдуулах тухай олон нийтэд зарласнаас хойш 4 хоногийн дараа байхаар тогтоож зарлана.

7. Ногдол ашиг авах эрх бүхий гишүүдийг тодруулахын тулд “бүртгэх өдрийг” ногдол ашиг хуваарилах тухай олон нийтэд зарласнаас хойш 4 хоногийн дараа байхаар тогтоож зарлана.

8. Ногдол ашиг хуваарилах тухай зарлахдаа дараах мэдээллийг олон нийтэд хүргэнэ.  
Үүнд:

1/ аль оны ногдол ашгийг хуваарилж байгаа.

2/нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ /татвар хассан дүнгээр.

3/ногдол ашиг авах эрх бүхий хувьцаа эзэмшигчийг тодруулах бүртгэх өдөр.

4/ногдол ашгийг олгож эхлэх өдөр.

5/ногдол ашгийг хаанаас авах.

9. Хувьцаат компани нь хурал хуралдуулах, ногдол ашиг хуваарилах өдрийг олон нийтэд зарлахаас 7 хоногийн өмнө энэ тухайгаа Монгол Улсын Үнэт цаасны хороо, Монголын хөрөнгийн биржид албан ёсоор мэдэгдэж холбогдох баримт бичгийг ирүүлнэ.

10. Монголын Хөрөнгийн бирж нь эрх бүхий этгээдээс албан ёсоор тогтоосон “Бүртгэх өдөр” явагдах арилжаагаар тасалбар болгон гишүүний бүрэн эрхийг баталгаажуулсан бүртгэлийг тухайн компанид үнэн зөв гаргаж өгнө.

11. Хурлыг зохион байгуулах эрх бүхий этгээд нь товлосон хугацаанд хурлыг хуралдуулна. Хурлын ирц хүрээгүй шалтгаанаар хуралдах өдрийг дахин тогтоон зарласан тохиолдолд өмнө товлосон бүртгэх өдрөөр баталгаажсан гишүүдийн бүрэн эрх хадгалагдана.

12. Хурлыг зохион байгуулах эрх бүхий этгээд нь хурал зарласан өдрөөс эхлэн уг хурлыг товлосон өдөр хүртэлх хугацаанд тухайн компанийн өмч хөрөнгийн ашиглалт, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх эдэлнэ.